

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд тогтвортой байлаа. S&P 500 индексийн сагсанд багтах компаниудын 3-р улирлын ашигт ажиллагаа шинжээчдийн таамаглаж байснаас өндөр байсантай холбоотой S&P 500 индекс бага хэмжээний өсөлттэй байлаа. S&P 500 индексийн сагсанд багтах эрүүл мэндийн салбарын компаниудын хувьцаа хамгийн их өсөлтийг үзүүлсэн бол IBM компанийн орлого хүлээлтээс доогуур байсантай холбоотой технологийн компаниудын хувьцаа хамгийн их бууралттай байлаа.

JP Morgan Chase, Goldman Sachs зэрэг компаниудын ашигт ажиллагаа хүлээлтээс өндөр байсан хэдий ч 2019 оны 3-р улиралд S&P 500 индексийн сагсанд багтах компаниудын дундаж ашигт ажиллагаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад бага зэрэг бууралттай байжээ.

Хэдий зарим компаниудын ашигт ажиллагаа хүлээлтээс дээгүүр байсан ч энэ долоо хоногийн эдийн засгийн үзүүлэлтүүд шинжээчдийн хүлээлтэд хүрээгүй байна. 9-р сарын үйлдвэрлэлийн гарц буурсан ба энэхүү бууралт нь General Motors компанийн ажилчид ажил хаясантай холбоотой юм. Энэ долоо хоногийн хамгийн их анхаарал татсан эдийн засгийн үзүүлэлт нь жижиглэнгийн худалдааны хэмжээ байсан ба энэхүү үзүүлэлт нь энэ оны 2-р сараас хойш анх удаагаа буурсан үзүүлэлттэй байлаа. Шинжээчдийн үзэж байгаагаар жижиглэнгийн худалдааны хэмжээ ажилгүйдлийн төвшин буурсан болон дундаж цалин өссөнтэй холбоотой цаашид өсөлт үзүүлэх хандлагатай байна.

Европ: Европын холбооны эрх баригчид Их британи улсын шинэ хэлэлцээрт гарын үсэг зурсантай холбоотой Европын хөрөнгийн зах зээл савалгаатай байлаа. Энэхүү хэлэлцээртэй холбоотой Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлт үзүүлсэн ч Их британи улсын Ерөнхий сайд ноён Борис Жонсон энэхүү хэлэлцээрийг батлуулж чадах нь эргэлзээтэй байгаагаас үүдэн индексүүд уналт үзүүлжээ.

Европын холбооны 27 улсын эрх баригчид хэлэлцээрийг дэмжсэнтэй холбоотой фунтийн ханш өнгөрөгч 5 сарын хамгийн дээд ханшинд хүрлээ. Гэхдээ, Хойд Ирландын Ардчилсан Нэгдэл нам Хойд Ирланд болон Бүгд Найрамдах Ирландын дунд хил байх ёсгүй хэмээн энэхүү хэлэлцээрийг дэмжихгүй гэдгээ илэрхийлсэн. Энэ Бямба гараг энэхүү хэлэлцээрийг Парламент дэмжихгүй бол Засгийн газар Brexit-ийн эцсийн хугацааг 10-р сарын 31-ний өдрөөс хойшлуулах хүсэлтийг Европын холбоонд тавих ба хойшлосон тохиолдолд дахин сонгууль явуулах эсвэл дахин олон нийтийн санал асуулга явуулах юм.

ХБНГУ 2020 оны эдийн засгийн өсөлтийн таамаглалаа 1.5%-аас 1.0% болгон бууруулсан ба 2019 оны эдийн засгийн өсөлтийн хүлээлтийг 0.5% хэвээр үлдээв. ХБНГУ-ын эдийн засгийн яамнаас Brexit болон улсуудын худалдааны маргаан нь ХБНГУ-ын экспортод сөргөөр нөлөөлж байна хэмээн мэдэгджээ.

Япон: Япон улсын статистикийн хорооноос суурь хэрэглээний үнийн индекс 2017 оны 4-р сараас хойших хамгийн бага төвшинд хүрснийг мэдэгдсэн нь Төв банк мөнгөний бодлогыг дахин зөөлрүүлэх шаардлагатай байгааг харууллаа. Мэдэгдлээс өмнө шинжээчдийн 85% нь Төв банкнаас эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээ авна хэмээн үзэж байжээ.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд бууралттай байлаа. Энэхүү бууралтын шалтгаан нь БНХАУ-ын 3-р улирлын эдийн засгийн үзүүлэлтүүд хүлээлтээс доогуур байсантай холбоотой юм. АНУ болон БНХАУ-ын худалдааны маргааны асуудал БНХАУ-ын эдийн засагт сөргөөр нөлөөлж буй нь цаашлаад дэлхийн эдийн засгийн хямралд хүргэхэд ойрхон байгаа юм.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,463.58	-2.83% ▼
Dow Jones	АНУ	26,770.20	-0.17% ▼
S&P 500	АНУ	2,986.20	0.54% ▲
Nasdaq	АНУ	8,089.54	0.40% ▲
S&P/TSX	Канад	16,377.12	-0.23% ▼
FTSE 100	Их Британи	7,150.57	-1.33% ▼
S&P/ASX 200	Австрали	6,649.70	0.65% ▲
Nikkei 225	Япон	22,492.68	3.18% ▲
Hang Seng	Хонг Конг	26,719.58	1.56% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.34
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	101.48
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.50
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.02
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.84
DBM' 2023	USD	7.250%	104.51
TDBM' 2020	USD	9.375%	102.50
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.16

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.850	-0.06 ▼
Libor 3M	1.950	-0.05 ▼
Libor 6M	1.950	-0.03 ▼
Libor 1YR	1.980	0.02 ▲
US 2YR Bond	1.592	0.00 ▲
US 3YR Bond	1.574	0.01 ▲
US 5YR Bond	1.583	0.03 ▲
US 10YR Bond	1.778	0.05 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.10.18	Өөрчлөлт
USD	2,679.03	0.32% ▲
CNY	378.48	0.16% ▲
EUR	2,980.42	1.29% ▲
RUB	41.89	1.01% ▲
KRW	2.27	0.89% ▲
JPY	24.66	-0.08% ▼
CAD	2,040.23	0.94% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,490.05	0.07% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	17.55	0.06% ▲
Зэс	USD/lb.	263.60	0.30% ▲
Нүүрс	USD/MT	68.80	0.54% ▲
WTI газрын тос	USD/bbl.	53.78	-1.68% ▼
Brent газрын тос	USD/bbl.	59.42	-1.80% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. VIII	8.90%
Бодлогын хүү	2019. VIII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. VIII	11.26%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. VIII	11.42%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. VIII	4.99%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. VIII	16.94%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. VIII	10.75%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 41 компанийн 236.7 сая төгрөгийн 1,085,508 ширхэг хувьцаа арилжаалагдав.


“Монгол шилтгээн” /MSH/ компанийн хувьцаа 14.81%-аар буюу хамгийн ихээр өсөж 310.0 төгрөгт хүрч хаагдсан бол “МИК Холдинг” /MIK/ компанийн хувьцаа 21.54%-аар буурч 11,290.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 1,772 ширхэг үнэт цаас 179.3 сая төгрөгөөр арилжаалагджээ.

10-р сарын 18-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,405.7 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,463.58 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 2.83%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	416.0
Зах зээлийн үнэлгээ	2,405,728.3

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,463.58	-2.83% ▼
MSE I индекс	8,383.49	-7.27% ▼
MSE II индекс	7,416.19	-0.28% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард санхүүгийн нэгдэл	44,775	58,006,821
АПУ	54,742	27,931,153
Ард кредит ББСБ	354,756	24,824,480
Таван толгой	2,908	18,649,400
Инвескор ББСБ	9,412	18,233,798

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол шилтгээн	310.00	14.81% ▲
УБ-БҮК	439.00	9.75% ▲
Ард санхүүгийн нэгдэл	1,346.00	7.34% ▲
Ремикон	25.49	5.72% ▲
Монос хүнс	67.49	4.80% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
МИК Холдинг	11,290.00	-21.54% ▼
Шарын гол	1,100.00	-13.66% ▼
Бүтээлч үйлс	1,100.00	-13.45% ▼
Техник импорт	9,000.00	-11.76% ▼
Төмрийн завод	7,640.00	-6.72% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Новел Инвестмент	274,485,024
Ард Секюритиз	157,868,320
Стандарт Инвестмент	109,668,222
Бумбат-Алтай	68,612,878
Голомт Капитал	35,348,819

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	506.40	538,902
Таван толгой	6,405.00	337,321
МИК Холдинг	11,290.00	233,808
Говь	274.00	213,751
Инвескор ББСБ	2,043.00	146,540

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	52	5,250,440	100,970	100,970	156	15.140%
2	ZGEB-BD-31/01/20-A0202-18	1,720	174,029,600	100,000	102,360	156	18.000%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дүти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.12-с
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.09.09-с

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” ХК нь Европын сэргээн босголт, хөгжлийн банкны оролцоотой 8 сая канад долларын санхүүжилтийн багц зарлалаа

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” ХК (TSX:ERD | MSE:ERDN) (цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь Европын сэргээн босголт, хөгжлийн банк (the “European Bank for Reconstruction and Development” буюу “EBRD”)-ны оролцоотой 8 сая канад долларын санхүүжилтийн багцыг танилцуулжээ. Эрдэнэ Ресурс нь EBRD-тэй хөрвөх нөхцөлтэй зээлийн гэрээ (“Зээлийн гэрээ”)-г баталгаажуулсан бөгөөд энэхүү зээлийн гэрээний хүрээнд Компани нь 5 сая америк долларын хөрвөх нөхцөлтэй зээлийг хүлээн авна. Үүнтэй зэрэгцэн, Эрдэнэ Ресурс нь 1.6 сая канад доллар хүртэл зуучлалгүй, хаалттай санхүүжилтийг хийхээр төлөвлөж байна. Санхүүжилтийн багц нь Компанийн Хөндий Алтны Төслийн (“Төсөл”) хараат бус эцсийн ТЭЗҮ (“FS”), анхны инженерчлэл загвар (“FEED”), хайгуул болон хөрөнгө оруулалтын зардлууд, ерөнхий ажлын капиталд зарцуулагдана.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Бэрх уул” ХК хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа зохион байгуулжээ.

“Бэрх уул” ХК /MSE:BEU/, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа 2019 оны 10-р сарын 18-ны өдөр хуралдуулжээ.

Энэ удаагийн хурлыг тус компанийн хамгийн том хувьцаа эзэмшигч Khanate Resource Holding S.A.R.L-ийн санал санаачлалаар зохион байгуулж байгаа бөгөөд хурлаар ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, шинээр сонгох юм.

Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2019 оны 9-р сарын 27-ны өдрөөр тогтоосон байна. Өөрөөр хэлбэл дээрх өдрөөр Бэрх уул /MSE:BEU/-ийн хувьцааг эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчид хуралд оролцох боломжтой байжээ.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Шинэст” ХК 2019 оны 3-р улирлын тайлангаа нийтэлжээ.

Ойн аж ахуй, мод бэлтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Шинэст” ХК /MSE:NRS/ 2019 оны 3-р улирлын санхүүгийн тайлангуудаа Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд нийтэлжээ.

“Шинэст” ХК нь 2019 оны 9-р сарын 30-ны байдлаар 183.1 сая төгрөгийн орлоготой, 287.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Компанийн хувьцааны хувьд, Монголын хөрөнгийн биржийн 3-р самбарт бүртгэлтэй ба хамгийн сүүлд 2018 оны 11-р сарын 21-ний өдөр 134 ширхэг хувьцааг нэгжийн 100 төгрөгөөр арилжаалсан байна.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК



Монголбанкны мэдэгдэл

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (Financial Action Task Force буюу ФАТФ)-аас 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр олон улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах явцын талаар мэдэгдэл гаргалаа.

Энэхүү мэдэгдэлд 2017 оны Харилцан үнэлгээний тайлан батлагдаж, хяналтад оруулснаас хойш Монгол Улс холбогдох хууль, тогтоомж журмыг шинэчилж нэвтрүүлснээр олон ахиц дэвшил гарсныг онцолжээ. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлаа нэмэгдүүлэх, дутагдлаа засаж сайжруулах чиглэлээр Монгол Улс ФАТФ болон Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх байгууллагатай хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх улс төрийн дээд түвшний хүсэл зоригоо илэрхийлснийг тэмдэглэсэн байна.

ФАТФ гишүүддээ хяналтанд оруулсан улс орнуудын эсрэг аливаа хориг арга хэмжээ авахыг шаардаагүй нь гадаад төлбөр тооцоо саатах, төлбөрийн карт хүчингүй болох, гадаад валютын урсгал багасах зэрэг шууд сөрөг нөлөөлөл үүсгэхгүй болохыг харуулж байна.

Монгол Улсын эдийн засаг төлөвлөсөн хэмжээндээ өсөж, төсөв алдагдалгүй, худалдааны болон төлбөрийн тэнцэл ашигтай гарч гадаад валютын нөөц өсөж эдийн засгийн эрсдэл даах чадвар сүүлийн 3 жилд үлэмж сайжраад байна. Монголбанкны зүгээс ФАТФ-ын хяналт нь төлбөр тооцоог зогсоох, санхүүгийн хэвийн зуучлалыг тасалдуулах, эдийн засгийн өсөлт, төгрөгийн тогтвортой байдлыг алдагдуулах нөхцөлийг үүсгэхгүй, үүсэж болох нөлөөллийг эдийн засгийн өнөөгийн хүчин чадлаар шийдвэрлэх бүрэн бололцоотойг үүгээр мэдэгдэж байна. Иймд ханшийн богино хугацааны зохиомол савлагаа үүсгэж, зах зээлийг төөрөгдөлд оруулах оролдлого гаргахгүй байхыг анхааруулж байна.

Эх сурвалж: Монголбанк

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Рио Тинто” төмрийн хүдрийн худалдаагаа юаниар хийж эхэллээ

Төмрийн хүдрийн үйлдвэрлэлээр дэлхийд хоёрдугаарт ордог “Рио Тинто” групп нь анх удаа юанийн төлбөрөөр худалдаа хийх гэрээ байгуулжээ. Гэрээ байгуулах ёслол Хятадын Шандун мужийн Рижао боомтод болсон байна. Энэхүү хамтын ажиллагааны эхлэл болгож тус улсын “Shanxi Gaoyi Steel” компани 10 мянган тонн 59.6%-ийн агууламжтай төмрийн баяжмал “Рио Тинто” группээс худалдан авчээ.

Ийм худалдааны хэлэлцээрийг ихэвчлэн далайн боомтууд шууд трейдер компаниудтай байгуулдаг. Гэсэн хэдий ч “Рио Тинто” групп нь Хятадын харилцагч нартай худалдааны сувгаа өргөжүүлж, компаниудаар дамжуулан тус улсын төвийн бүс нутгийн гангийн үйлдвэрүүдэд шууд түүхий эд нийлүүлэхээр зорьж байна.

Бразилийн “Вале” компани төмрийн хүдрийн худалдаандаа 2016 оноос юанийн төлбөрийг нэвтрүүлсэн байдаг. “Рио Тинто” группийн хувьд, Австралийн төмрийн хүдрийн үйлдвэрлэгчдээс анх удаа юанаар худалдаа хийж байгаа юм.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

Ноолуур дунджаар 53-64 мянган төгрөгийн үнэтэй байна

Ямааны цагаан ноолуурын үнэ Орхон, Хөвсгөл аймагт кг нь 65 мянган төгрөг байна. Энэ нь хамгийн өндөр үнэ бөгөөд бусад аймагт дунджаар 53-64 мянган төгрөгийн үнэтэй байна. Баянхонгор, Булган, Дорнод аймагт ноолуур кг нь 50 мянган төгрөг байгаа нь хамгийн бага үнэ болж байна.

ҮСХ-ноос гаргасан малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр нас гүйцсэн эр хонь Орхон аймагт 200 мянган төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ болж байна. Харин Дорнод аймагт эр хонь 125 мянган төгрөгийн үнэтэй байна.

Хонины ноостой нэхийний дундаж үнэ Орхон аймагт 3.5 мянган төгрөг, Завхан, Увс аймагт 1.5 мянган төгрөг, бусад аймагт 2.5-3.0 мянган төгрөг байна.

Эх сурвалж: Montsame.mn

Ургац хураалт энэ долоо хоногт дуусна

Улсын хэмжээнд энэ 7 хоногийн байдлаар 233.5 мянган тонн ургац хураалт хийгдээд байна. Үүнээс 167 мянган тонн хүнсний ногоо, 70.2 мянган тонн тэжээл, 51 мянган тонн тосны ургамал хурааж аваад байгааг ХХААХҮЯ-наас мэдээлж байна.

Өнөөдрийн байдлаар төмс хүнсний ногооны ургац хураалт дуусаад байна. Үр тариа хураалт 70-аад хувьтай байна. Энэ долоо хоногийн сүүлч гэхэд ургац хураалтын ажлыг дуусгах төлөвлөгөөтэй байгаа талаар ХХААХҮЯ-ны Газар тариалан хөгжлийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Болорчулуун мэдээллээ.

Гурилын үйлдвэрүүд буудайгаа авч, төмс хүнсний ногоо эрхлэгчид борлуулалтаа хийж байна. Улаанбаатар хотын 40 гаруй цэгт хүнсний ногоо худалдаж байна. Шинэ ногооны 30 орчим хувийг хүнсний борлуулах үйлдвэрүүд авч, үлдсэн 30 орчим хувийг зоорилдог байна. Сүүлийн жилүүдэд хүнсний ногоогоор дотоодын эрдсийн 50 орчим хувийг хангаж байна. Үүнд манжин, луувангийн хангамж сайн. Сонгино, сармис, байцаа дутмаг байдаг. Тийм учраас үр тариа тариалдаг ААН-үүд сүүлийн үед сонгино, сармисны тариалалт руу анхаарч эхэлжээ.

Эх сурвалж: Montsame.mn

ҮСХ: Зэсийн экспорт 4.5%-иар буурлаа

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр, энэ оны эхний есөн сарын байдлаар манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 10.5 тэрбум ам.долларт хүрч 9.5%-аар өсжээ. Үүнд экспорт 5.9 тэрбум ам.доллар, импорт 4.6 тэрбум ам.долларыг эзэлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад экспорт 12.6%, импорт 5.7%-иар тус тус өслөө. Гадаад худалдаа 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарч өнгөрсөн оны мөн үеийнхээс 415.5 сая ам.доллараар нэмэгджээ.

Нийт экспортод эзлэх эрдсийн экспортын хэмжээ 4.96 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 9.3%-иар нэмэгдсэн байна. Энэ дундаа нүүрсний экспорт орлогын дүнгээр тэргүүлж буй бол зэс хоёрдугаарт эрэмбэлэгдэв.

Оны эхний есөн сарын байдлаар Монгол улсын нүүрсний экспорт 28.7 сая тонн буюу 2.4 тэрбум ам.долларт тэнцэж, жингийн хувьд 5%-иар, мөнгөн дүнгийн хувьд 14.3%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Сарын дүнгээр авч үзвэл, өнгөрсөн есдүгээр сард 3.7 сая тонн нүүрсний экспорт хийсэн нь өмнөх наймдугаар сарынхаас 10 орчим хувиар буурсан дүн болж байна.

Зэсийн баяжмалын экспортын тухайд оны эхний есөн сарын байдлаар нийтдээ 1 сая 66 мянган тоннд хүрч, мөнгөн дүнгээр 1.42 тэрбум ам.долларт хүрлээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад жингээр 0.6%-иар, үнийн дүнгийн хувьд 4.5%-иар тус тус буурсан байна. Цэвэр зэсийн хувьд экспортын хэмжээ 7.45 орчим мянган тоннд хүрч, мөнгөн дүнгээр 43.4 орчим сая ам.доллар болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс жингийн хувьд 25.9%-иар, үнийн дүнгээр 33.4%-иар тус тус буурсан дүн юм.

Төмрийн хүдрийн тухайд оны эхний есөн сард экспорт жингээр 6.13 сая тоннд хүрсэн нь 15.4%-ийн өсөлтийг, үнийн дүнгээр 422 сая ам.долларт хүрсэн нь 75.7%-ийн өсөлтийг харууллаа.

Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алтны экспорт мөн хугацаанд 7.5 тонн буюу 344 сая ам.долларт тэнцсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад жингийн хувьд 2.2 дахин, үнийн дүнгийн хувьд 2.4 дахин өссөн дүнтэй гарчээ. Гэхдээ Монголбанкны мэдээллээр, оны эхний есөн сарын хугацаанд Төв банкны алт худалдан авалт 11.2 тоннд хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 3.1 тонноор буюу 22%-иар буурсан байгаа юм.

Жоншны хүдэр, баяжмалын тухайд оны эхний есөн сард 500 мянган тонныг гадагш нийлүүлж, 155 сая ам.долларт тэнцсэнээр жингийн хувьд 45.1%, орлогын тухайд 34%-иар тус тус нэмэгджээ.

Цайрын хүдэр, баяжмалын экспортыг авч үзвэл, мөн хугацаанд нийтдээ 100.7 мянган тоннд бүтээгдэхүүн нийлүүлж, 145 сая ам.долларын орлого олсон нь жингийн хувьд 9.2%-иар өссөн ч үнийн дүнгийн хувьд 5.5%-иар буурлаа.

Молибденийн баяжмалын экспорт оны эхний есөн сард 4.2 мянган тоннд хүрч 37.1 сая ам.долларт хүрснээр жингээр 4.5%-иар буурсан ч орлогын хувьд 3.1%-иар нэмэгджээ.

Хар тугалгын хүдэр, баяжмалын экспортын хувьд оны эхний есөн сарын хугацаанд 17.6 орчим мянган тонн бүтээгдэхүүн нийлүүлж, 38 сая ам.долларын орлого олсон байна. Энэ нь жингийн хувьд 16.4%, орлогын дүнгээр 0.8%-иар тус тус өссөнийг илтгэнэ.

Гянтболдын экспортын тухайд 490.6 тоннд хүрч 4.79 сая ам.долларын орлого олсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс жингийн хувьд 7%-иар өссөн бол, үнийн дүнгийн хувьд 5.4%-иар буурсан дүнтэй гарлаа.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

БУСАД МЭДЭЭ

Монгол улсын эдийн засгийн 2019 оны 9-р сарын байдал

Мөнгө, зээл

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 9-р сарын эцэст 20.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 60.9 (0.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.5 (13.9%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 9-р сарын эцэст 889.8 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 35.9 (3.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 39.3 (4.2%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 9-р сарын эцэст 18.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 105.2 (0.6%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 1.8 (11.1%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 9-р сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 59.7 (3.1%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 613.5 (45.1%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.6 пунктээр өссөн байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш 2019 оны 9-р сард 2 669.68 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар суларч, өмнөх сараас 0.03 хувиар чангарсан байна. Монголбанкнаас зарласан төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2019 оны 9-р сард 375.28 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар суларч, өмнөх сараас 0.8 хувиар чангарсан байна. Монголбанкнаас зарласан төгрөгийн рубльтай харьцах сарын дундаж ханш 2019 оны 9-р сард 41.15 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.1 хувиар, өмнөх сараас 1.2 хувиар суларсан байна.

Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 7.7 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 7.3 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 484.6 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 9-р сард 872.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 31.5 (3.7%) тэрбум төгрөг, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 937.8 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 111.1 (13.4%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 81.0 хувийг татварын орлого, 8.5 хувийг татварын бус орлого, 9.7 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 0.8 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 79.6 хувь, хөрөнгийн зардал 18.2 хувь, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 2.2 хувийг эзэлж байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 746.2 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 435.5 сая америк доллараар буурчээ.

Урсгал данс 807.5 сая америк долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 1.0 тэрбум америк доллар, анхдагч орлогын данс 1.0 тэрбум америк долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн данс 2019 оны эхний 8 сард 61.3 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 6.9 (12.7%) сая америк доллараар өссөн байна. Харин санхүүгийн дансны тэнцэл 909.3 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 123.6 (12.0%) сая америк доллараар буурчээ.

Төлбөрийн тэнцэл 2018 оны эхний 8 сард 397.8 сая америк долларын алдагдалтай байсан бол 2019 оны эхний 8 сард өмнөх оны мөн үеэс 436.8 сая америк доллараар өсөж, 39.0 сая америк долларын ашигтай гарчээ.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 9-р сард улсын хэмжээнд өмнөх сараас өөрчлөлтгүй, өмнөх оны эцсээс 5.4 хувь, өмнөх оны мөн үеэс 9.0 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 9-р сард өмнөх оны мөн үеэс 9.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 15.6 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 37.2 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 4.7 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.6 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 8.9 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 2.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 11.3 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 14.4 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 5.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 9-р сард өмнөх оны эцсээс 5.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 11.7 хувь (мах, махан бүтээгдэхүүн 32.4 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 9-р сард өмнөх сараас өөрчлөлтгүй гарахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувиар буурсан хэдий ч орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 0.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.